



**“ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК”  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ДҮРЭМ**

2021 оны 12 наадамжийн  
Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.“Ди Би Эм Асset Менежмент УЦК” (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үnэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2.Компанийн оноосон нэр нь монгол хэлээр “Ди Би Эм Асset Менежмент УЦК” ХЦК буюу “Ди Би Эм Асset Менежмент УЦК” хязгаарлагдмал хариуцлагатай компани байх бөгөөд англи хэлээр “DBM Asset Management SC” LLC буюу “DBM Asset Management SC” Limited Liability Company байх бөгөөд компанийн товчилсон нэр нь монгол хэлээр “Ди Би Эм Эй Эм Эс Си” ХЦК, англи хэлээр “DBM AM SC” LLC байна.

1.3.Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот - 14240, Сүхбаатар дүүрэг, нэгдүгээр хороо, Жамъян гүний гудамж 18, Даун Таун барилгад байрлана.

1.4. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах дантай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.

1.5.Компани нь Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

1.5.1. хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх.

1.6.Компани нь тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх нэмэлт үйл ажиллагааг хууль, журамд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэнд хавсан эрхэлж болох ба энэ тохиолдолд дүрэмдээ зохих өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.7.Компани нь бусадтай байгуулсан гэрээний үндсэнд энэ дүрмийн 1.5.1-д заасан үйл ажиллагааг дараах үйл ажиллагаатай хавсан эрхэлж болно.

1.7.1. хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах;

1.7.2. даатгалын компанийн нөөц хөрөнгийг итгэмжлэн удирдах.

1.8.Компани үйл ажиллагаагаа хугацаагүйгээр эрхэлнэ.

1.9.Компанийн хөрөнгө оруулсан дотоод, гадаадын хуулийн этгээд болон хөрөнгө оруулалтын санд компанийг төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн удирдамжийн дагуу Гүйцэтгэх захирал төлөөлж болно.

1.10. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.11. Компани нь үүсгэн байгуулах баримт бичиг, хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

## **Хоёр. Компанийн эрх**

2.1.Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

2.2.Компани нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга хэрэглэнэ.

2.3.Компани нь Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд байгуулсан компанийг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.4.Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.5.Компани нь үндсэн ба хавсрал эрхлэх үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай ажилтныг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулж болох бөгөөд, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээт тогтооно.

## **Гурав. Компанийн үүрэг**

3.1.Компани нь энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхэлнэ.

3.2.Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3.Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.

3.4.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивд шилжүүлнэ.

## **Дөрөв. Компанийн хариуцлага**

4.1.Компани нь Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

4.2.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3.Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.

4.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

## **Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө**

5.1.Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 (тавин мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх ба нийт үнийн дүн нь 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг байна.

5.2.Хувьцаа эзэмшигчийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг бүр нь 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 (тавин мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх ба нийт үнийн дүн нь 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг байна.

5.3.Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.

5.4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг баримтална.

5.5.Компани нь энгийн болон давуу эрхийн хувьцаанд хөрвөх өрийн бичиг /бонд/ болон опционыг хуульд заасан журмын дагуу гаргаж болно.

5.6.Компани нь эргэлтэд гаргах энгийн болон давуу эрхийн хувьцаа, өрийн хэрэгслийн төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хүлээн авч болно.

5.7.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр аливаа гүйлгээ хийхээс өмнө эрх бүхий зохицуулагч байгууллагын зөвшөөрөл авна.

### **Зургаа. Хувьцаа эзэмшигч, түүний эрх, үүрэг**

6.1.Компанийн үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Хөгжлийн банк байна.

6.2.Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлэх үүргийг хариуцахгүй, хувьцаа эзэмшигч нь компанийн хүлэх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү компанийд оруулсан хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

6.3.Хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлнэ:

6.3.1.хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, эзэмшиж буй хувьцааныхаа тоотой хувь тэнцүүлсэн хэмжээгээр санал өгөх;

6.3.2.компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийг сайжруулах талаар санал гаргах;

6.3.3.төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эзэмшиж буй хувьцааныхаа тоотой хувь тэнцүүлсэн хэмжээний ногдол ашиг авах;

6.3.4.компани татан буугдсан тохиолдолд хууль тогтоомжийн дагуу компаниас бусдын өмнө хүлээсэн үүргийг зохих ёсоор биелүүлсний дараа үлдэж буй хөрөнгөөс эзэмшиж буй хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлсэн хэмжээгээр өөрт ногдох хувийг авах;

6.3.5.компани нэмж хувьцаа гаргах тохиолдолд өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлсэн хэмжээгээр тэргүүн ээлжид худалдан авах;

6.3.6.компанийн хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, санхүүгийн тайлантай танилцах.

6.4. Хувьцаа эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ:

6.4.1.компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцох;

6.4.2.компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх, компанийн нэр хүнд, өмч хөрөнгөнд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахгүй байх;

6.4.3.компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, бие даасан, үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, компанийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа бодлого, шийдвэрийг дэмжиж ажиллах;

6.4.4.хууль тогтоомж болон энэхүү дүрмээр бүрэн эрхэд нь хамааруулснаас бусад асуудлаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд оролцохгүй байх.

### **Долоо. Хувьцаа эзэмшигчдийн хурал**

7.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

7.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс итгэмжлэгдсэн этгээд хэрэгжүүлнэ.

7.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь шийдвэр хэлбэртэй байна.

7.4.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.

7.5.Ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрөв) сарын дотор зарлан хуралдуулна.

7.6.Дүрмийн 7.5-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн компанийн дүрмээр тогтоосон хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно.

7.7.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

7.8.Ээлжит бус хурлыг хууль тогтоомжид заасан үндэслэл болон Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд хуралдуулж болно.

7.9.Тогтоол болон тэмдэглэлд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

#### **Найм. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх**

8.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

8.1.2.нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

8.1.3.компанийн ерийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

8.1.4.компанийн хэлбэрийг өөрчлөх;

8.1.5.компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

8.1.6.хувьцааг хуваах буюу нэгтгэх;

8.1.7.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

8.1.8.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.1.9.Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэх;

8.1.10.Компанийн тухай хуулийн арван хоёдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх тухай шийдвэрийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэх;

8.1.11.компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

8.1.12.компанийн зарласан болон гаргасан хувьцааны хэмжээг тогтоож, компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хууль тогтоомжид заасны дагуу нэмж хувьцаа гаргах төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах;

8.1.13.компанийн үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн зорилго, чиглэлийг тодорхойлох;

8.1.14.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн болон дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг батлах;

8.1.15.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

8.1.16.хууль тогтоомж, дүрэмд заасан бусад асуудал.

## **Ес. Төлөөлөн удирдах зөвлөл**

9.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

9.2.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь гурван гишүүнтэй байх ба тэдгээрийн нэг нь хараат бус гишүүн байна.

9.3.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж, чөлөөлнө.

9.4.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил, хараат бус гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байх ба ердийн гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно.

9.5.Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдхөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл Компанийн төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно.

9.6.Энэ дүрмийн 9.5-д заасан үндэслэлээр хугацаанаасаа өмнө чөлөөлөгдсөн гишүүний оронд нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь тухайн чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

9.7.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр гишүүнийг Монгол Улсын Хөгжлийн банк нэр дэвшүүлнэ.

9.8.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан байна.

9.8.1.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшигдэггүй;

9.8.2.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

9.8.3.төрийн үйлчилгээний албанаас бусад төрийн алба хашдаггүй;

9.8.4.компанитай бизнесийн аливаа холбоогүй;

9.8.5.хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.

9.9.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна Компанийн тухай хуульд заасан нэмэлт үүргийг хүлээнэ.

9.10. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь жилд 1-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

9.11. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

9.12. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно.

9.13. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.

9.14. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

## **Арав. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

10.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

10.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хурлыг товлон зарлах, хурал даргалах үүргийг хүлээнэ.

10.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон гишүүн гүйцэтгэнэ.

#### **Арван нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал**

11.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байна.

11.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулна.

11.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, гүйцэтгэх захирлын санаачилга, шаардлагаар хуралдуулж болно.

11.4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдуулна.

11.5. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг эчнээ санал хураалтаар эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

11.6. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хүчин төгөлдөр болно.

11.7. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.

11.8. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлагдана.

11.9. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

11.10. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулна.

11.11. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл /протокол/-ийг хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

11.12. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн хурлын тэмдэглэл /протокол/-д гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргана.

11.13. Хурлын тэмдэглэл /протокол/-ийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

11.14. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зөвхөн өөрийн биеэр хуралд оролцож эрх хэмжээгээ хэрэгжүүлэх бөгөөд өөр этгээдээр төлөөлүүлж хуралд оролцохыг хориглоно. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хуралд биеэр оролцоогүй боловч тухайн хэлэлцэж буй асуудлын талаар бичгээр санал гаргасан бол түүнийг хуралд оролцсонд тооцно.

11.15. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүд хуралд оролцох, асуудал хэлэлцэх, эчнээ санал хураалтаар асуудал шийдвэрлэх, хурлын дэгийг тогтоох, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүрэг болон бусад холбогдох асуудлыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

#### **Арван хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

12.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

12.1.1. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

12.1.2. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

- 12.1.3. Компанийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг батлах, өөрчилөх;
- 12.1.4. Батлагдсан бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалтын хүрээнд орон тооны дээд хязгаарыг тогтоох;
- 12.1.5. хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, бүрэн эрхийг тогтоох;
- 12.1.6. гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал, урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоож, тогтоосон нөхцөлийн дагуу гэрээ байгуулах зөвлөөрлийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргад олгох;
- 12.1.7. дотоод аудитыг томилох, чөлөөлөх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоож, тогтоосон нөхцөлийн дагуу гэрээ байгуулах зөвлөөрлийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргад олгох;
- 12.1.8. хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- 12.1.9. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- 12.1.10.гүйцэтгэх захирлаас танилцуулсан компанийн дотоод дүрэм, журмыг батлах;
- 12.1.11. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 12.1.12. компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах шийдвэр гаргах, түүний дүрэм эсхүл үйл ажиллагааны журмын батлах;
- 12.1.13. их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн үнэ болон уг гэрээг байгуулах эсэх талаар шийдвэр гаргах;
- 12.1.14. хөрөнгө оруулагчийн тодорхойлсон чиглэлийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах, сангийн дүрмийн төслийг батлах;
- 12.1.15. компанийн өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах эсэх талаар шийдвэр гаргах;
- 12.1.16. төсөв, төсвийн тодотгол, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- 12.1.17. компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, дунд болон урт хугацааны бизнес төлөвлөгөөг батлах;
- 12.1.18. эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрх (компанийн хувьцаа болон бусад үнэт цаасыг оролцуулан)-ийн зах зээлийн үнийг тогтоох;
- 12.1.19. компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;
- 12.1.20. ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах;
- 12.1.21.энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээс бусад бүх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

#### **Арван гурав. Компанийн гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх, үүрэг**

13.1. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Компанийн төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийн эрх ашгийн төлөө түүнийг Монгол Улс болон хилийн чанадад төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

13.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

13.3. Гүйцэтгэх захирлыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, өөрчилнэ.

13.4. Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно.

13.5. Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомжид заасан болон дараах шалгуурыг хангасан байна.

13.5.1. эдийн засгийн болон санхүүгийн чиглэлээр дээд боловсролтой, хөрөнгө удирдлагын чиглэлээр мэргэшсэн, удирдах ажлын гурав болон түүнээс дээш жилийн туршлагатай байх;

13.5.2. зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа ергүй байх;

13.5.3. ял шийтгэлгүй байх;

13.5.4. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

13.6. Гүйцэтгэх захирал нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэх эрх авсан байна.

13.7. Гүйцэтгэх захирал нь дараах бүрэн эрхийг эдэлнэ.

13.7.1. гүйцэтгэх захирал эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана;

13.7.2. гүйцэтгэх захирал нь өөрийн удирдлагад ажиллах компанийн зохион байгуулалтын нэгжийн захиралтай гэрээ байгуулах бөгөөд гэрээнд нэгжийн захирлын эрх, үүрэг, цалин, шагнал урамшуулал, хангамж, өмч хөрөнгийг захирсан зарцуулах эрх, хариуцлагын хэмжээ болон бусад асуудлыг тусгана;

13.7.3. компанийн дотоод журам, заавар, аргачлал, хүний нөөцийн бодлого, ажил үүргийн хуваарь баталж мөрдүүлэх;

13.7.4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд нэгжийн захирал, ажилтныг ажилд томилох, нийт ажилтны ажлын байрны тодорхойлолт, цалингийн сүлжээг батлах, батлагдсан цалингийн сүлжээний хүрээнд цалин, урамшууллын хэмжээг тогтоох, ажилтны нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

13.7.5. мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

13.7.6. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээний хүрээнд хамаарах асуудлаар компанийг төлөөлөх, итгэмжлэл олгох;

13.7.7. компанийн эд хөрөнгийг эрх хэмжээнийхээ хүрээнд захирсан зарцуулах;

13.7.8. эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого, чиглэлтэй уялдуулан толгой болон охин компанийн үйл ажиллагааны уялдааг хангах;

13.7.9. хөрөнгө оруулалтын сантай байгуулах түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах;

13.7.10. хууль болон энэхүү дүрэм, гэрээнд заасан бусад.

13.8. Гүйцэтгэх захирал нь дараах үүрэгтэй:

13.8.1. компанийн үйл ажиллагааг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө бүрэн хариуцаж, жилд 1-ээс доошгүй удаа ажлын үр дүнгээ тайлagnаж, дүгнүүлэх;

13.8.2. компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, эрх бүхий этгээдэд тайлагнаж мэдээлэх үүрэгтэй бөгөөд түүний үнэн зөвийг хариуцах;

13.8.3. хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн хэрэгжилтийг хангуулах;

13.8.4. компанийн бизнес төлөвлөгөө, жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.8.5. компанийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэй холбогдсон асуудлаар Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

- 13.8.6. компанийн нууцад хамаарах мэдээлэл, материалын жагсаалт болон нууц хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан мөрдүүлэх;
- 13.8.7. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- 13.8.8. хөрөнгө оруулагч, компанийн харилцагчийн шаардсан бусад хөрөнгө оруулагчтай хийж байгаа хэлэлцээрийн шатны, эсхүл компанийн стратеги, бизнесийн нууцад хамаарах мэдээллийс бусад компанийн үйл ажиллагаа, тэдгээрийн хөрөнгөтэй холбоотой аливаа мэдээллийг гаргаж өгөх;
- 13.8.9. зохицуулагч байгууллагын шаардсан баримт материалыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх;
- 13.8.10. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
- 13.8.11. үүрэг гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;
- 13.8.12. компанийн шинээр худалдан авах, худалдах, шилжүүлэх болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулах;
- 13.8.13. компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар гаргасан тушаалын биелэлтийг хангуулах.

13.9. Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан Хөдөлмөрийн гэрээнд заасан чиг үүрэг, бизнес төлөвлөгөөнд заасан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд дотоод, гадаадын мэргэжлийн зөвлөх болон зөвлөх багийг хөлсөөр ажиллуулах, эсхүл зөвлөх үйлчилгээг авч болно.

13.10. Албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол гүйцэтгэх захирлыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхийг нь дуусгавар болгож, чөлөөлнө.

#### **Арван дөрөв. Компанийн эрх бүхий албан тушаалтан**

14.1. Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, дотоод хяналтын албаны ахлах хянагч, гүйцэтгэх захирал, нэгжийн захирал, хөрөнгө оруулалтын сангийн менежер, срөнхий нягтлан бодогч төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар нь компанийн эрх бүхий албан тушаалтан байна.

14.2. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх болон бусад мэдээллийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч энэхүү дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

- 14.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэг, хариуцлага хүлээнэ.
- 14.3.1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;
- 14.3.2. үйл ажиллагаандaa компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;
- 14.3.3. үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар явуулж, хувьцаа эзэмшигч, харилцагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;
- 14.3.4. шууд болон шууд бус байдлаар эсхүл гуравдагч талын нэрийн өмнөөс компанийд нөлөөлж болох аливаа хэлцэл, материаллаг сонирхолтой асуудлын талаар компанийн төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;
- 14.3.5. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

14.3.6. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол тухай бүр Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, дотоод хяналтын албаны ахлах мэргэжилтэн эсхүл удирдах албан тушаалтанд мэдэгдэх ба тухайн асуудлаар санал өгөхгүй байх;

14.3.7. чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;

14.3.8. компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орох бүрд 10 хоногийн дотор компанид мэдэгдэх;

14.3.9. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

14.4. Компанийн гүйцэтгэх захирлыг зохицуулагч байгууллагын олгосон зөвшөөрлийг үндэслэн томилох бөгөөд уг зөвшөөрөл гарах хүртэлх хугацаанд гүйцэтгэх захирал нь үүрэг гүйцэтгэгчээр ажиллана.

14.5. Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн туршид энэ дүрмийн 14.3.9-д заасан үүргийг биелүүлнэ.

14.6. Өөрийн буруугаас компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтанд хуульд заасан хариуцлагыг оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэж болно.

#### **Арван тав. Компанийн үйл ажиллагаанд тавих хяналт**

15.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

15.1.1. дотоод хяналт;

15.1.2. хөндлөнгийн хяналт.

15.2. Дотоод хяналтыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон 3-аас доoshгүй орон тооны гишүүнтэй алба эсвэл мэргэжлийн аудитын байгууллага хэрэгжүүлэх бөгөөд ахлах хянагч нь аудитын үйл ажиллагаа явуулах, үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэх эрх авсан байна.

15.3. Дотоод хяналтыг хэрэгжүүлэгч нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр нөлөөт байдлыг эмх цэгцтэй, системтэйгээр үнэлэн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах, гүйцэтгэх захирлын хүсэлт бүхий захиалгын үндсэнд компанийн нэгж, ажилтны үйл ажиллагаанд хяналт тавьж гүйцэтгэх захиралд танилцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

15.4. Дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална.

15.5. Компани нь хөндлөнгийн хяналтын зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хөндлөнгийн аудитын байгууллагаар гүйцэтгүүлнэ.

15.6. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод хяналтыг хэрэгжүүлэгч аудитын байгууллага болон зохицуулагч байгууллагад бүртгэлтэй хөндлөнгийн аудитын байгууллагыг хууль тогтоомжийн дагуу сонгож, түүнтэй гэрээ байгуулна.

15.7. Дараах этгээдийг хөндлөнгийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно:

15.7.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн гэрээний үндсэн дээр хөлсөөр ажиллаж буй ажилтан, эрх бүхий албан тушаалтан;

- 15.7.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан давуу эрхийн хувьцаанаас бусад үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшидэг;
- 15.7.3. аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар компанийтай хэлцэл хийсэн, бизнесийн хариулцаатай этгээд;
- 15.7.4. хөндлөнгийн аудитын байгууллагын тайланг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана.

**Арван зургаа. Компанийн охин болон хараат компани, салбар, төлөөлөгчийн газар**

16.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дангаараа болон бусад хуулийн этгээдтэй хамтран хараат, охин компанийг үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн хувьцааг нь шилжүүлж болон худалдан авах замаар хараат, охин компани байгуулах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, шийдвэрлүүлнэ.

16.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай тохиолдолд салбар, төлөөлөгчийн газрыг дотоодод болон гадаад улсад нээн ажиллуулж болно.

16.3. Төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

16.4. Салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.

16.5. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.

16.6. Салбар, төлөөлөгчийн газар нь компанийн албан ёсны хэвлэмэл хуудас, салбар төлөөлөгчийн газрын тэмдэг хэрэглэнэ.

16.7. Салбар, төлөөлөгчийн газрын захирлыг компанийн гүйцэтгэх удирдлага томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

**Арван долоо. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа**

17.1. Компанийн санхүүгийн жил нь хуанлийн жилтэй ижил байна.

17.2. Компани нь нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, жилийн тайланг аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч, эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

17.3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

17.4. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд жилд нэгээс доошгүй удаа Компанийн төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрээр сонгосон аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

**Арван найм. Ногдол ашиг хуваарилах**

18.1. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах бөгөөд энэхүү шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

18.2. Энэхүү дүрмийн 18.1-д заасан шийдвэр гаргасан өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч байна.

18.3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг төлөх хугацаанаас өмнө өөрийн эзэмшлийн хувьцааг бусад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигч буюу энэ дүрмийн 18.2-т заасан этгээдэд үлдэнэ.

18.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

18.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байх бөгөөд уг хугацаанд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлээгүй тохиолдолд дараа жилийн санхүүгийн тайлан гарах хүргэл ногдол ашиг олгохгүй.

18.6. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

#### **Арван ес. Компанийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа**

19.1. Компани нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж, түүний болон бусад сангийн хөрөнгийг удирдах болон энэ дүрэмд заасан үйл ажиллагаа явуулна.

19.2. Компани нь эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хамтран санг үүсгэн байгуулж болно.

19.3. Хөрөнгө оруулалтын сантай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд компанийг төлөөлж Гүйцэтгэх захирал, тухайн сангийн менежерийн хамт гарын үсэг зурж баталгаажуулна.

19.4. Компани нь өөрийн үүсгэн байгуулсан, эсхүл хөрөнгийн удирдлагыг нь хэрэгжүүлж байгаа сангийн хөрөнгө оруулагчид ашиг олох, тэдгээрийн нэгж эрхийг сангийн хөрөнгөөр тодорхой үнэ ханшаар эргүүлэн авах амлалт, баталгаа гаргах, сангийн хэлбэрээс хамаарч тогтоосон хязгаараас хэтрүүлэн зээл авах бусад зээл олгох үйл ажиллагаа явуулахгүй.

19.5. Компани нь сантай байгуулсан гэрээнд заасан зардлын төлбөр, гүйцэтгэлийн урамшуулал, санд үйлчилгээ үзүүлсэн этгээдэд төлөх төлбөрөөс бусад төлбөр, хураамжийг сангийн хөрөнгөөс гаргахыг хориглоно.

19.6. Компани өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах бол зөвхөн өөрийн үүсгэн байгуулсан, эсхүл хөрөнгийн удирдлагыг нь хэрэгжүүлж байгаа санд тэдгээрийн дүрэмд заасан хэрэгслээр хөрөнгө оруулж болно.

19.7. Компанийн сантай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа нь тухайн сангийн үйл ажиллагаа явуулах хугацаатай адил байна.

19.8. Компани нь үйлчилгээ үзүүлж байгаа сан, харилцагчид түүний кастодианы болон бусад үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьцааг худалдан авах замаар нэгдмэл сонирхлыг бий болгох үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

19.9. Компанийт байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгөө удирдуулж байгаа үйлчлүүлэгч этгээдийн хөрөнгөөр өөрийн удирдах байгаа санд хөрөнгө оруулалт хийж болно.

19.10. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг Хороонд бүртгүүлсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрх авсан мэргэшсэн нягтлан бодогчоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

19.11. Компанийн ажилтан нь зохицуулагч байгууллагаас тогтоосон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллана.

19.12. Компани нь тусгай зөвшөөрлийн үндсэнд эрхлэх үйл ажиллагаандаа зах зээлийг урвуулан ашиглах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга сахин ажиллана.

19.13. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30.2-д заасан этгээдийн шийдвэрээр санг татан буулгах үйл ажиллагааг сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасны дагуу тухайн шийдвэр гаргасан этгээдээс томилсон комисс зохион байгуулна.

#### **Хорь. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах**

20.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

20.2. Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.

20.3. Компанийг татан буулгах шийдвэр гаргах эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.

20.4. Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

20.5. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10-д заасан, Компанийн тухай хуулийн 26-28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

20.6. Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад ирүүлнэ.

#### **Хорин нэг. Бусад**

21.1. Энэхүү дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж, улсын бүртгэлийн байгууллага, ҮҮСГЭН байгуулагч болон компани тус бүр нэг хувийг хадгална.

21.2. Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.

21.3. Энэхүү дүрмийг англи хэлнээ хөрвүүлэх тохиолдолд эрх бүхий баталгаат орчуулгын байгууллага хөрвүүлэх бөгөөд аливаа маргаантай асуудал үүсвэл дүрмийн Монгол хувилбарыг баримтална.

~oOo~